



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13 № 321

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ТУШААЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ШҮРЭНЦЭЦЭГ
ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалтаай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,474.0 сая төгрөгийн өртөгтэй 1000 ширхэг иж бүрэн хүлэмжийг бараа материалын тайлангийн тусгай зориулалтын материал дансанд 1 ширхэг материалаар бүртгэсэн,
- Дотоод албан томилолтын зардлаас дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэргүйгээр байгууллагын даргад 1.6 сая, нягтлан бодогчид 5.5 сая төгрөгийг олгосон,
- Тээвэр шатахууны зардлаас албан томилолтгүйгээр 12.1 сая төгрөгийн шатахуун, батлагдсан хоол, унааны зардлын хэмнэлтийг оны эцэст газрын даргын 2024 оны Б/34 дүгээр тушаалаар зориулалт бусаар зарцуулсан,
- Ажил олгогч ажилтныг илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, хамтын гэрээ, хэлэлцээр байхгүй, зориулалт бусаар газрын даргын 2024 оны Б/33 тушаалаар 2 албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон,

632500638

- Албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, бараа үйлчилгээний бусад зардал, бусад бараа үйлчилгээний зардлаас албан томилолт, шатахуун, шагнал урамшуулал, тэмцээн уралдаан, урсгал зардалд 74.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Айрагны баяр, Алтаргана зэрэг арга хэмжээний шагналд 12.9 сая төгрөгийг бэлэн мөнгөөр олгохоор зарцуулсныг суутган төлөгчийн ТТ-12 тайлангаар 6.5 сая төгрөгийн шагналыг няравт олгосноор тайлагнасан,
- Цалингийн зардалд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд цалингийн зардлаас 0.9 сая төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд бүлэг хооронд зориулалт бусаар шилжүүлсэн,
- Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн системтэй давхардуулан, салбартаа дахин систем боловсруулахаар Даталанд Технологи ХХК-тай 2024 оны 12-р сарын 24-ний өдрийн ҮГ-2024-36 дугаартай "Программ хангамжийн үйлчилгээний гэрээ" байгуулан үргүй зардал гаргасан,
- Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого чанартай хийгдээгүй, тооцоо бодсон актаар үлдэгдэл баталгаажуагүй,
- Бэлтгэн нийлүүлэгчдтэй хийсэн гэрээ байхгүй, харилцагч нартай тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдээгүй, батлагдсан төсвийг хэтрүүлэн ахмадын баярын арга хэмжээнд 3,607.0 мянган төгрөгийг өглөгөөр тайлагнасан,
- Өмнөх оны төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй,
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээ дутуу, 52,947.9 мянган төгрөгийг илүү мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 52,480.1 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, тухай бүр мэдээлэх хавсралт файлыг мэдээлээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь УСНББОУС-1, 12, 17, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.13, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 4, 5 дахь заалт, 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам, Сангийн сайдын Зардлын ангилал баталсан 2021 оны 190 дүгээр тушаал, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргаар 93.5 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнэ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон тавилга эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамжийг акталж, данснаас хасах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай 227.6 сая төгрөгийн 159 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны Б/16 тушаал, Булган аймгийн ХХААГ-ын даргын 2024 оны Б/15 дугаар тушаалаар 13 албан хаагчдад 92.5 сая төгрөгийг олгохоор гаргасан шийдвэрт нягтлан бодогчийг хамруулсан байна.

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,911.0	3,220,966.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	335,978.4	338,833.2
	Нийт хөрөнгийн дүн	440,889.3	3,559,799.2
	Нийт өр төлбөрийн дүн	-	3,607.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	440,889.3	3,556,192.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	440,889.3	3,559,799.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	922,762.1	4,522,107.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	891,182.7	1,406,804.7
	Үйл ажиллагааны үр дүн	31,579.4	3,115,302.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	(36,931.7)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(5,352.3)	3,115,302.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,036.9	440,889.3
	Тайлант оны үр дүн	(5,352.3)	3,115,302.9
	Эцсийн үлдэгдэл	443,684.5	3,556,192.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	881,780.9	1,264,578.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	881,780.9	1,264,578.7
	Үйл ажиллагааны ЦМГ	(0.0)	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	670,814.4	991,967.4
	Урсгал зардал	670,814.4	991,967.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	670,814.4	991,967.4
	Улсын төсвөөс санхүүжих	670,814.4	991,967.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар санхүүгийн батламж мэдэгдлийн түвшинд нийт 3,986,691.6 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрсэнд, 3,881,207.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 105,483.9 мянган төгрөгийн 4 алдаанд зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг бэлтгэж ирүүлээгүй гүйцэтгэлийн шатанд нөхөж авч залрууллаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн зөвлөмжийг харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд 8,299.8 мянган төгрөгийн авлагыг үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулаагүй, 3,537.0 мянган төгрөгийн өглөгийн батлагдсан маягтаар баталгаажуулсан гэх боловч, ахмадын баярын арга хэмжээнд зарцуулсан цагаан идээ, хүнс, хоолны зардлыг журналд бичилт хийгээгүй, зохион байгуулсан талаар тайлан байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2, 14.4.3 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө өглөг, авлагыг заавал бүртгэж хэвших.

Аудитаар нийт 407,750.2 мянган төгрөгийн 14 зөрчил² илэрснээс, 10,563.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 399,021.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 294,360.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 53,003.8 мянган төгрөгийн 2 зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 341,378.7 мянган төгрөгөөр их, тархцын хүрээ өргөн тул Сөрөг дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Аймгийн шуурхай штаб дээр батлагдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар тус газрын 5 албан хаагчийг илүү цагаар ажиллуулахаар гаргасан шийдвэртэй хамт батлагдсан төсвийг зориулалт бусаар ажил илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, нягтлан бодогч, захиргаа аж ахуйн албаны даргад 895.9 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3, 103.3.4, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 4, 5, 5.1 дэх заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

2.Ердийн галлагаатай сууцанд амьдардаг 14 албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авахад зориулж олгосон 9,794.5 мянган төгрөгийг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

3. Албан томилолтоор дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэргүй, томилолтын зардлыг томилолтоор ажиллах үеийн хугацаанд олгоогүй, сарын мэдээнд томилолтын өглөгөөр мэдээлээгүй, нягтлан бодогчид Улаанбаатар хотод тайлан мэдээ нэгтгүүлэх, Сайхан суманд оготно устгалтаар ажилласан гэх 5,529.0 мянган төгрөг, байгууллагын даргад 1,628.0 мянган төгрөгийг олгосон нь 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6 “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1.Хоол унааны зардлын батлагдсан төсөв 6910 төгрөг байхад хэмнэгдсэн зардлыг оны сүүлд газрын даргын 2024 оны Б/34 дүгээр тушаалаар албан хаагчдад 9,399.7 мянган төгрөгийг зориулалт бусаар олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлээ.

2.Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн системтэй давхардуулан Даталанд Технологи ХХК-тай 2024 оны 12-р сарын 24-ний өдөр “Программ хангамжийн үйлчилгээ”, ҮГ-2024-36 дугаартай гэрээг байгуулж 7,200.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

3.Суутган төлөгчийн ТТ-12 тайлангаар няравт 6,500.0 мянган төгрөгийн шагнал олгосноор тайлагнасан нь Алтаргана, айрагны баярын арга хэмжээний тэмцээн уралдаанд зориулж жолооч болон нярвын харилцах дансаар 12,400.0 мянган төгрөгийг дамжуулан авч зарцуулсан нь нотлогдохгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1, 16 дугаар зүйлийн 5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 13.1 дэх заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1, 4.2.1.6 дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

4.Бараа материал болон үндсэн хөрөнгийн дансдын үлдэгдэлд тооллого хийх тушаал гаргасан боловч тооллогыг үр дүнтэй хийгээгүй, 3,559,799.2 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, зарцуулсан шатахууныг жолоочийн тооцооны хуудсаар зарцуулсан шатахуунтай тулган баталгаажуулахад 391.6 мянган төгрөгөөр дутуу, албан томилолтгүй 12,094.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан “Жишиг норм батлах тухай” журам, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, ний сэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-т “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.1-т “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

5.Өмнөх онд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан газрын даргын тушаалаар 1,671.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон, Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж олгосон 40,000.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэргүй, хэн хэзээ төлөх нь тодорхойгүй, гэрээ контракт байхгүй, эрх мэдлээ хэтрүүлэн, зориулалт бусаар зарцуулсанд тогтоогдсон төлбөрийн актыг төлөөгүй, үндсэн хөрөнгийн тайлангийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 106 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй хөрөнгийн талаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийг **хугацаанд нь биелүүлээгүй**, санхүүгийн тайлангийн **аудитаар сөрөл дүгнэлт авсан** зөрчлүүд нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.5 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэсэн заалтыг тус тус үндэслэн эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайланд анхны өртгөө бүрэн нөхсөн 159 нэр төрлийн 227,628.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй, хөрөнгийн үлдэгдэлтэй тооллогоор баталгаажаагүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эргэлтийн 100ш хүлэмжийг 1 ширхгээр бөөн дүнгээр бүртгэлд зөрүүтэй бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнэ нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөл, холбогдох газруудад шийдвэрлүүлэх ажил зохион байгуулан, УСНББОУС-17 мөрдөж ажиллах.

1.2 Илрүүлэлт: 210801 зардлаас 49,696.3 мянга, 210901 зардлаас 16056.8 мянган төгрөгөөр эдийн засгийн ангилал зөрчиж томилолт, шатахуун, шагнал урамшуулал, тэмцээн уралдаан, урсгал зардалд зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитой төлөвлөж, төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын журмыг хэрэгжүүлэн үнэн зөв тайлагнаж хэвших.

1.3 Илрүүлэлт: Цалингийн зардалд горим хэрэгжүүлэхэд ажил олгогчийн НДШ-ийн зардлаас даатгуулагчийн НДШ-д бүлэг хооронд гүйлгэн шилжүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитой төлөвлөж, Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын журмыг хэрэгжүүлэн үнэн зөв тайлагнаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)												
Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг бэлтгэж ирүүлээгүй гүйцэтгэлийн шатанд нөхөж авч залрууллаа.	1	3,881,207.8	1	3,881,207.8	1	3,881,207.8						
Тайлант хугацаанд 8,299.8 мянган төгрөгийн авлагыг үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн батлагааны маягтаар баталгаажуулаагүй, 3,537.0 мянган төгрөгийн өглөгийн батлагдсан маягтаар баталгаажуулсан гэх боловч, ахмадын баярын арга хэмжээнд зарцуулсан цагаан идээ, хүнс, хоолны зардлыг журналд бичилт хийгээгүй, зохион байгуулсан талаар тайлан байхгүй байна.	1	11,836.8	1	11,836.8					1	11,836.8	1	11,836.8
Дүн	2	3,893,044.6	2	3,893,044.6	1	3,881,207.8	1	3,881,207.8	1	11,836.8	1	11,836.8

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс										
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Аймгийн шуурхай штаб дээр батлагдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар тус газрын 5 албан хаагчийг илүү цагаар ажиллуулахаар гаргасан шийдвэртэй хамт батлагдсан төсвийг зориулалт бусаар ажил илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, нягтлан бодогч, захиргаа аж ахуйн албаны даргад олгосон	1	895.9	1	895.9							
	1	2,510.0	1	2,510.0							
	1	7,157.0	1	7,157.0							
Албан томилолтоор дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэргүй, томилолтын зардлыг томилолтоор ажиллах үеийн хугацаанд олгоогүй, сарын мэдээнд томилолтын өглөгөөр мэдээлээгүй, нягтлан бодогчид Улаанбаатар хотод тайлан мэдээ нэгтгүүлэх, Сайхан суманд оготно устгалтаар ажилласан гэх зориулалт бусаар зарцуулсан.	1	9,399.7	1	9,399.7							
Хоол унааны зардлын батлагдсан төсөв 6910 төгрөг байхад хэмнэгдсэн					1	9,399.7					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 52,947.9 мянган төгрөгийг 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4 гүйлгээ зөрүүтэй мэдээлсэн, тухай бүр мдээлэх хавсралт файлууд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал хэсэгт хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээллээгүй, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг оруулах мэдээлэл байхгүй төлвөөр мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан 5 мэдээллийг мэдээллээгүй байна.	1	52,480.1			1	52,480.1			
Дүн	1	52,480.1			1	52,480.1			



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 03 дугаар сарын 13

Дугаар 01/196

Булган сум

АДБЖОАБЗ

БМА - 2025/110/НА - СТА - ТУБЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ердийн галлагаатай сууцанд амьдардаг 14 албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авахад зориулж олгосон 9,794,540.00 (есөн сая ерэн дөрвөн мянга таван зуун дөчин) төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэлийн 2,510,200.00 (хоёр сая таван зуун арван мянга хоёр зуун) төгрөгийг суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас суутгаагүй 2,510,200.00 (хоёр сая таван зуун арван мянга хоёр зуу) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

Ч. Шүрэнцэцэг

632505850



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 13

Дугаар 02/197

Булган сум

А0670253

БУА - 2025/10/11А - СТА-ТУЛЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн шуурхай штаб дээр батлагдсан хуваарийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар тус газрын 5 албан хаагчийг илүү цагаар ажиллуулахаар гаргасан шийдвэртэй хамт батлагдсан төсвийг зориулалт бусаар ажил илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, нягтлан бодогч, захиргаа аж ахуйн албаны даргад 895,991.46 (найман зуун ерэн таван мянга, есөн зуун ерэн нэг төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3-т "ажил олгогч хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн цалин хөлсний талаар дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж мөрдүүлнэ", 103.3.4-т "цалин хөлсний журам", Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 4-д "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно", 5-д "дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно", 5.1-д "энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол" дэх заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг

632505650

үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Шийдвэргүй олгосон 895,991.46 (*найман зуун ерэн таван мянга есөн зуун ерэн нэгэн төгрөг дөчин зургаан мөнгө*) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 12

Дугаар 03/198

Булган сум

АД 670А53

БҮА-2025/110/НА-ЦТА-ТМБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэргүй, томилолтын зардлыг томилолтоор ажиллах үеийн хугацаанд олгоогүй, сарын мэдээнд томилолтын өглөгөөр мэдээлээгүй, нягтлан бодогчид Улаанбаатар хотод тайлан мэдээ нэгтгүүлэх, Сайхан суманд оготно устгалтаар ажилласан гэх 5,529,000.00 (таван сая таван зуун хорин есөн мянга) төгрөг, байгууллагын даргад 1,628,000.00 (нэг сая зургаан зуун хорин найман мянга) төгрөгийг олгосон байна.

Энэ нь 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар зарцуулсан

632505656

7,157,000.00 (долоон сая нэг зуун тавин мянга долоон зуу) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/123

Булган сум

AD БҮТӨС 3

БҮА - 2025/110/НА - ДТА - тус

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материал болон үндсэн хөрөнгийн дансдын үлдэгдэлд тооллого хийх тушаал гаргасан боловч тооллогыг үр дүнтэй хийгээгүй, 3,559,799,216.82 (гурван тэрбум таван зуун тавин ес долоон зуун ерэн есөн мянга хоёр зуун арван зургаа төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, зарцуулсан шатахууныг жолоочийн тооцооны хуудсаар зарцуулсан шатахуунтай тулган баталгаажуулахад 391,600.00 (гурван зуун ерэн нэг мянга зургаан зуу) төгрөгөөр дутуу, албан томилголтгүй 12,094,068.00 (арван хоёр сая ерэн дөрвөн мянга жаран найм) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" журам, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын

632504429

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР



Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 03/24

Булган сум

QD670253

ДАН-2025/110/НА-ЛТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоол унааны зардлын батлагдсан төсөв 6910 төгрөг байхад хэмнэгдсэн зардлыг оны сүүлд газрын даргын 2024 оны Б/34 дүгээр тушаалаар албан хаагчдад 9,399,720.00 (есөн сая гурван зуун ерэн ес долоон зуун хорь) зориулалт бусаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн
ШААРДАХ нь:

1.Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

632504433



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 04/125

Булган сум

АДБ-70253

БҮА-2025/110/НА - ЛТА-ТНБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Суутган төлөгчийн ТТ-12 тайлангаар няравт 6,500,000.00 (зургаан сая таван зуу) төгрөгийн шагнал олгосноор тайлагнасан нь Алтаргана, айрагны баярын арга хэмжээний тэмцээн уралдаанд зориулж жолооч болон нярвын харилцах дансаар 12,400,000.00 (арван хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг дамжуулан авч зарцуулсан нь нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Буруу тайлагнасан 6,500,000.00 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт даалгав.

632504442


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/122

Булган сум

АДБ-70253

ДУР-2025/110 - НА - ЕТӨ - ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн системтэй давхардуулан Даталанд Технологи ХХК-тай 2024 оны 12-р сарын 24-ний өдөр "Программ хангамжийн үйлчилгээ", УГ-2024-36 дугаартай гэрээг байгуулж 7,200,000.00 (долоон сая хоёр зуу) төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн

ШААРДАХ нь:

1.Үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан 7,200,000.00 (долоон сая хоёр зуун мянга) төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16 -ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), нягтлан бодогч (Л.Отгон) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

57144798
ГТ01148 3190269

632504413



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 14

Дугаар 06/131

Булган сум

А0670.253

ЗУН 2025/11.0/НА-СТА ТУНС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төслийг хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 52,947,900.00 (тавин хоёр сая есөн зуун дөчин долоон мянга) төгрөгийн 5 гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 52,480,155.00 (тавин хоёр сая дөчин найман мянга нэг зуун тавин таван мянга) төгрөгийн 4 гүйлгээ, мөн тухай бүрд мэдээлэх нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гаргаагүй, хавсралт файлыг мэдээлээгүй, өмнөх оны шилэн дансны зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан,
2. Өмнөх онд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан газрын даргын тушаалаар 1,671,000.00 (нэг сая зургаан зуун далан нэг) төгрөгийн балансын урамшуулал олгосон, Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж олгосон 40,000,000.00 (Дөчин сая) төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэргүй, хэн хэзээ төлөх нь тодорхойгүй, гэрээ контракт байхгүй, эрх мэдлээ хэтрүүлэн, зориулалт бусаар зарцуулсанд тогтоогдсон төлбөрийн актыг төлөөгүй, үндсэн хөрөнгийн тайлангийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 106 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй хөрөнгийн талаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийг хугацаанд нь биелүүлээгүй,
3. Санхүүгийн тайлангийн аудитаар **сөрөг** дүгнэлт авсан зөрчлүүд нь нийсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, 6.10-д "шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд

632504450

нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн "42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын гаргасан алдаа зөрчлийг арилгах ажил зохион байгуулж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР



Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА

2025 оны 03 дугаар сарын 14

Дугаар 05/180

Булган сум

А0670233

А0670233/10/НА/СТА - ТИЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төслийг хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 52,947,900.00 (тавин хоёр сая есөн зуун дөчин долоон мянга) төгрөгийн 5 гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 52,480,155.00 (тавин хоёр сая дөчин найман мянга нэг зуун тавин таван мянга) төгрөгийн 4 гүйлгээ, мөн тухай бүрд мэдээлэх нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гаргаагүй, хавсралт файлыг мэдээлэлгүй, өмнөх оны шилэн дансны зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан,
2. Өмнөх онд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан газрын даргын тушаалаар 1,671,000.00 (нэг сая зургаан зуун далан нэг) төгрөгийн балансын урамшуулал олгосон, Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж олгосон 40,000,000.00 (Дөчин сая) төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэргүй, хэн хэзээ төлөх нь тодорхойгүй, гэрээ контракт байхгүй, эрх мэдлээ хэтрүүлэн, зориулалт бусаар зарцуулсанд тогтоогдсон төлбөрийн актыг төлөөгүй, үндсэн хөрөнгийн тайлангийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 106 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй хөрөнгийн талаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийг хугацаанд нь биелүүлээгүй,
3. Санхүүгийн тайлангийн аудитаар **сөрөг** дүгнэлт авсан зөрчлүүд нь нийсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, 6.10-д "шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд

632504437

нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Дээрх нягтлан бодогчийн гаргасан зөрчилд сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ